



МОНГОЛ УЛС  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах журам батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1.“Төрийн бус байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх журам батлах тухай” 30 дугаар тогтоол, 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх журам батлах тухай” 23 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН

000035

Сонгуулийн Ерөнхий Хорооны  
2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн  
16 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, АЖИГЛАЛТ ХИЙХ, СУРГАЛТ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллагаас /цаашид төрийн бус байгууллага гэх/ сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, сонгогчдийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх, сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд оролцохдоо Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3.Төрийн бус байгууллага нь аливаа улс төрийн нам, нэр дэвшигч, төрийн байгууллага, албан тушаалтны аливаа нөлөөнөөс ангид, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж, сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд ажиллана.

1.4.Төрийн бус байгууллага нь энэ журамд заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлж дараах төрлийн үйл ажиллагааг явуулах эрхтэй.

1.4.1.сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх;

1.4.2.сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах, сургалт явуулах;

1.4.3.сонгогчдод эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх;

1.4.4.сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх.

**Хоёр. Төрийн бус байгууллагыг бүртгэх**

2.1.Төрийн бус байгууллага нь энэ журмын 1.1-д заасан үйл ажиллагаа явуулах тухай хүсэлтээ ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш Сонгуулийн Ерөнхий Хороонд бичгээр ирүүлнэ.

2.2.Төрийн бус байгууллага нь энэ журмын 2.1-д заасан хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсаргана:

2.2.1.байгууллагын дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.2.2.энэ журмын 1.4-т заасны дагуу явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө;

### 2.2.3.байгууллагын санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл.

2.3.Энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор хянан үзэж шаардлага хангасан төрийн бус байгууллагатай гэрээ байгуулна. Ингэхдээ дараах байдлыг харгалзан үзнэ. Үүнд:

2.3.1.аливаа улс төрийн намын харъяалалын бус, /нэр дэвшигч/;

2.3.2.улс төрийн нам, эвслээс санхүүждэггүй байх.

2.4.Сонгуулийн Ерөнхий Хороотой гэрээ байгуулсан төрийн бус байгууллагыг үйл ажиллагаагаа явуулахад нь байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагууд дараах боломжоор хангана:

2.4.1.үндсэн ба зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах,

2.4.2.санал хураах, тоолох төхөөрөмж болон түүний програмыг туршин шалгах ажиллагааг ажиглах;

2.4.3.санал авах байранд 1 ажиглагч томилон ажиллуулах;

2.4.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодод ирсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх мэдээлэл авах;

2.4.5.саналын хуудсыг хэвлэх, түүний хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, аюулгүй байдал, битүүмжлэн хадгалах ажиллагаанд ажиглагчаар оролцох;

2.4.6.радио, телевизээр нэвтрүүлж буй сонгуулийн сурталчилгаа Сонгуулийн тухай хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих;

2.4.7.гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах;

2.4.8.нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалттай танилцах.

### **Гурав. Төрийн бус байгууллагын эрх, үүрэг**

3.2. Төрийн бус байгууллагын эрх:

3.2.1.сонгуулийн байгууллагаас авах шаардлагатай хуулиар хориглоогүй мэдээ, мэдээллийг гаргуулан авах;

3.2.2.өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай, хуулиар хориглоогүй дэмжлэг туслалцаа авах;

3.2.3.энэ журмын 2.2.2-т заасан төлөвлөгөөний хүрээнд хийсэн, ажлын тайланг Сонгуулийн Ерөнхий Хороонд танилцуулж, үр дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах, хэвлэн нийтлэх.

3.3.Төрийн бус байгууллагын үүрэг:

3.3.1.Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;

3.3.2.сонгуулийн байгууллагын болон сонгогчийн хууль ёсны эрхийг хүндэтгэх;

3.3.3.сонгогчдод сонгуулийн хууль тогтоомж сурталчлахдаа өөрийн үзэмжээр, хуульд заагаагүй зөвлөгөө өгөх, аливаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сонгуулийн сурталчилгаа явуулахгүй байх;

3.3.4.ажлын тайлан, санал дүгнэлтээ санал хураалт дууссанаас хойш 30 хоногийн дотор Сонгуулийн Ерөнхий Хороонд бичгээр ирүүлэх;

3.4.Энэ журамд заасныг зөрчсөн төрийн бус байгууллагад Сонгуулийн хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.